

## **ТАТВАРЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ, ТҮҮНИЙГ ПРАКТИКТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ**

Төрийн оршин тогтнох үндсийг бүрдүүлж байгаа татварын тогтолцоог урьдын замнал, хуучин аргачлалаараа явуулбал орчин үеийн түвшинд ажиллаж, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй. Иймээс Монгол улсын татварын албаны шинэчлэлийг өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүргэхээр 2009 оноос эхлэн зорилт тавьж, 2012 онд үйл ажиллагааны хэтийн стратеги чиглэлийг тодорхойлж ох замаар шинэчлэлийн бодлогыг боловсруулсан.

Шинэчлэлийн бодлогын гол зорилго:

- Татварын албыг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэсэн, татвар төлөгчдийн итгэлийг хүлээсэн, нээлттэй, ил тод шударга үйл ажиллагаатай хууль хэрэгжүүлэгч байгууллага болгох
- Татварын алба захиргаанд хурт алын аппарат байхаасаа татгалзаж, татвар төлөгчдөө төрийн үйлчилгээг өндөр ёс зүйтэй, соёлтой, чирэгдэлгүй, шуурхай үйл ажиллагаа явуулсан үйлчилгээний байгууллага болгох
- Монгол улсын татварын албыг орчин үеийн, өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүргэсэн татварын алба болгох явдал юм.

Энэхүү зорилгыг хангахаар татварын албаны шинэчлэлийн бодлогын хүрээнд тодорхой хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Татварын албаны шинэчлэл, ил тодын хөтөлбөр
2. Татварын албаны хэмжээнд авилга, хээл хахуультай тэмцэх хөтөлбөр
3. “Татварын жишиг алба” хөтөлбөр
4. Татварын албаны албан хаагчдын сургалтын хөтөлбөр
5. Татварын албаны гадаад хамтын ажиллагааны хөтөлбөр

Хөтөлбөрүүд нь 2009-2012 он хүртэл үе шаттай хэрэгжих бөгөөд уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

- Татварын албаны үйлчилгээнд хүнд суртал, ашиг сонирхолын зөрчлийг бий болгож байгаа ажлын байр, албан тушаалтан, чиг үүргийг судлах
- Татварын албаны бүтэц зохион байгуулалт дахь сул тал, дутагдлыг илрүүлэх, түүнийг засаж боловсронгуй болгох хяналт шалгалтын

байцаагчийн үйл ажиллагааг электрон байдлаар бүртгэлжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд дотоод хяналтын механизмыг бий болгох

- Татвар төлөгч нь өөрийн байгаа газраасаа электрон сүлжээ ашиглан татварын байгууллагатай харилцах боломжийг бүрдүүлэх
- Татвар төлөгчөөс Татварын албаны үйл ажиллагааг сайжруулах талаар тогтмол хугацаанд судалгаа авч үнэлгээ хийж ажиллах
- Татвар өлөгчдөд хөнгөн шуурхай нээлттэй, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлдэг, энэхүү үйлчилгээг хэрэгжүүлж буй байдалд нь татвар төлөгчид үнэлгээ дүгнэлт өгч сайжруулах талаар саналаа илэрхийлдэг болсон байх
- Татварын алба болон татвар төлөгчдийн хоорондын хамтын ажиллагаа сайжирч Татварын алба нь татвар төлөгчдийн найдвартай түнш болсон байх
- Татвар төлөгчдийн дунд татварын албаны нэр хүнд дээшилж, татварын байгууллага нь нээлттэй, ил тод шударга үйлчилгээтэй гэсэн үнэлгээ, үзэл, бодол төлөвшсөн байх.

### ***Шинэчлэлийн бодлогыг практикт хэрэгжүүлж байгаа нь:***

Татварын албаны үйл ажиллагааны шинэчлэлийн бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор Улсын өсвийн орлого хяналтын газар /УТОХГ/ нь ихээхэн шинэлэг ажлуудыг хийж байна.

Улсын өсвийн орлого хяналтын газар нь өдөр тутмын үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод, чадварлаг, хариуцлагатай, оюунлаг, шударга, шуурхай үйлчилгээг эрхэмлэн ажиллаж байна.

2009 онд тус газар нь Татварын албаны системд “Загвар” нэгж болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилтын үрээнд дараахь ажлуудыг зохион байгуулж, хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Засгийн Газар, Сангийн Яам, Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан, хүчин төгөлдөр мөрдө гдөж байгаа татварын хууль тогтоомж, дүрэм, журам, аргачлал, заавар, тушаалуудын заалт бүрийг үйл ажиллагааныхаа мөчлөг бүрт мөрдөн, хэрэгжилтийн байдалд нь судалгаа, дүгнэлт хийн, татвар төлөгчдийн санал хүсэлтийг хүлээн авах замаар практикт нийцэхгүй заалтуудыг өөрчлөх, ингэснээр шат шатанд гарсан шийдвэр хэрэгжиж, дотоод ажлын арга барил /технологи/-д зарчмын шинэчлэл хийсэн.

2009 оны 1 үдээр сарын 23 -ны өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 67 дүрэм, журам, заавар, аргачлалыг байцаагч бүрээр судлуулан, оюун ухааны зураглалд оруулж, гарын авлага бэлтгэн, дотооддоо хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн явцад 17 эрх зүйн актад өөрчлөлт оруулах, 6 эрх зүйн актыг шинэчлэх, 3 эрх зүйн актыг шинээр боловсруулах талаар гаргасан санал дүгнэлтүүдийг нэгтгэн Татварын Ерөнхий Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хэлэлцүүлгийн материалыг Сургалт судалгааны төв болон нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.

Мөн Татварын удирдлага хамтын ажиллагааны хэлтэс /ТУХАХ/, Хууль эрх зүйн хэлтэс /ХЭЗХ/, УТОХГ-ууд хамтран цаашид хийгдэх хэлэлцүүлгийн үр дүнгээр дүрэм, журам, аргачлал, зааварт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Татварын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх үүрэг бүхий комиссыг байгуулан ажиллуулж байна.

Энэхүү ажлыг 2010 онд өргөжүүлж 2009 онд шинээр батлагдсан 33 дүрэм, журам, аргачлал, зааварын хэлэлцүүлгийн хуваарийг гарган Татварын ерөнхий газрын бодлогын хэлтсүүд болон Нийслэл, дүүргийн татварын албадад хүргүүлэн, тэднийг урин оролцуулж, оролцогчдын хүрээг нэмэгдүүллээ.

2. Ажиллагсадынхаа мэдлэг, мэргэжил, боловсрол, ажилцэггэх чадвар, дадлага, туршлагыг ахисан үвшингээр дээшлүүлэн, оюунлаг байдлыг эрхэмлэж, оюуны өрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажлын эх суурийг тавих зорилготой байнгын хэлэлцүүлэг хийх, сургалт явуулах, мэргэжлийн дадлага эзэмшүүлэх, илтгэх ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Оюуны жим” клубыг 2009 онд байгуулсан. Санал асуулгын үндсэн дээр хэлэлцүүлэгт орох илтгэлүүдийн сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулж, байцаагч бүр илтгэл бэлтгэж, хуваарийн дагуу 31 илтгэл хэлэлцүүлэгдэж, товхимол, сургалтын материал хэвлүүлэн гаргахаар ажиллаж байна.
3. Газрын хамт олны 70-аас доошгүй хувийг мэргэшсэн нягтлан бодогч, нягтлан бодогч-хуульч гэх мэт хос мэргэжилтэй болгох зорилт тавин ажиллаж, “Загвар” нэгжид ажиллах Татварын улсын байцаагчийн шалгуур зүүлэлтийг тогтоон, мөрдөн ажиллаж байна.

4. Судалгааны ажлыг боловсронгуй болгохтой холбогдуулан судалгаанд хамрагдах үзүүлэлтүүдийн сонголтыг хийж, банк, уул уурхай, мэдээлэл, харилцаа холбоо, барилгын салбараар суурь судалгаануудыг хийж, цаашдын чиг хандлагыг тодорхойлж, холбогдох дүгнэлтүүдийг гаргасан.

УТОХГ нь 2009 онд эхлэн хэрэгжсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн 2010 онд татвар төлөгчдөд чиглэсэн дараахь шинэлэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Сонирхолтой, найрсаг, инээмсэглэлтэй ажлын байрыг бий болгохтой холбогдсон болон Татварын албаны хэмжээнд өрдөгдөж байгаа “Жишиг татварын алба”, “Үндэсний татварын албаны хэмжээнд авилга, хээл хахуультай тэмцэх”, “Татварын албаны шинэчлэл, ил тодын төлбөр” -үүдийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, ажиллуулж үр дүнг нь улирал бүр газрын ажилтнуудын хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байна.
2. Оюунлаг татварын албыг өгжүүлэх ажлын хүрээнд “Оюуны жим” клубын үйл ажиллагааг өргөжүүлэхээр 2010 онд хэлэлцүүлэгдэх илтгэлийг Татварын Ерөнхий Газрын бүх газар, хэлтэс болон МУИС, ММНБИ зэрэг бусад байгууллагуудтай хамтран бэлтгэж, илтгэлүүдийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэлэлцэж байна.
3. “Татвар төлөгчдөөр татварын улсын байцаагчдын ажлыг үнэлүүлж, дүгнүүлэх” ажлыг Татварын албаны хэмжээнд анх удаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Татвар төлөгчөөр татварын улсын байцаагчдын ажлыг “Үнэлгээний хуудас” /Хавсралт/-аар үнэлүүлсэн байдалд дүгнэлт хийж үзэхэд 2010 оны эхний хагас жилийн нийт өгсөн 723 үнэлгээний 10 буюу 1.3% нь “шаардлагыг төдийлэн хангахгүй байгаа”, 8 буюу 1.1% нь “шаардлагыг хангахгүй байгаа” гэсэн үнэлгээ авсан байна. Энэ нь тус газрын ажиллагсад өөрсдийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажилласаны үр дүн гэж үзэж байна. Татварын улсын байцаагчдын татвар төлөгчдөд үзүүлж буй үйлчилгээ нь шаардлагад нийцэж байгааг харуулж байна.
4. “Цаасгүй орчинг бий болгох үйл ажиллагаа”-г нэвтрүүлэх тусгай төлөвлөгөөг гарган шинээр дотоод мэдээлэл, файл солилцох **Ipmsg** программ болон бүртгэлтэй татвар төлөгчдөд нэгдсэн байдлаар зар, мэдээлэл хүргэх, сурталчилгаа хийх **Mass mailer** программыг ашиглаж байна. Татвар төлөгчдөөс лавлагаа, тодорхойлолт авах хүсэлтийг хүлээн авах, тэдний асуултанд хариулах,

зөвлөгөө өгөх зорилгоор [tax\\_utohg@mta.mn](mailto:tax_utohg@mta.mn) цахим хаягыг шинээр нээн ашиглаж байна.

Зураг 1. Цаасгүй орчны мэдээллийн урсгал



Хүснэгт 1. 2010 оны 8 дугаар сарын 31-ний байдлаарх цаасгүй орчны мэдээлэл

Цахим хаягаар хүлээн авсан хүсэлтийн тоо	628
Татвар төлөгчдөд өгсөн лавлагаа, тодорхойлолтын тоо /давхардсан тоогоор/	727
Татвар төлөгчдийн асуултанд цахимаар хариу, зөвлөгөө өгсөн тоо	142
Татвар төлөгчдөд нэгдсэн журмаар хүргүүлсэн мэдээний тоо /хуулийн өөрчлөлт, сургалтын зар, урилга гэх мэт/	13
Нэгдсэн зар мэдээ хүргүүлсэн тоо	36

Дээрхи хэрэгжүүлж байгаа ажлын үр дүнг дараахь байдлаар үнэлж байна. Үүнд:

- Дээд газраас гарсан шийдвэрийн биелэлтийг хэрэглэгчээс санал боловсруулах хэлбэрээр удирдлагадаа мэдээлдэг системд шилжих ажлын эхлэл болсон;
- Байцаагчдыг өөрийгөө илэрхийлэх, илтгэх ур чадварыг дээшлүүлэх бололцоог хангасан. Мөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэлүүдийг хамт олноороо хэлэлцсэн;
- Хэлэлцүүлгийн явцад практикт нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай олон асуудлуудыг гарган тавьж, Татварын албаны газрын бодлогын асуудал

хариуцсан нэгжүүдэд зохих саналыг тухай бүр албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна;

- Судалгааны ажлуудыг хийсний үр дүнд тус газартай харилцагч аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн нөхцөл байдал, нөлөөлж байгаа хүчин зүйлсүүдийг тодорхойлж, татварын орлогын боломжийг вэвз тооцон, эрсдлийг урьдчилан тооцоход тус дөхөм үзүүлсэн;
- Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээгээ шинэ шатанд гаргах, татвар төлөгчдөөр ажлаа дүгнүүлэх системд шилжсэнээр татвар төлөгчдийн татварын албанд итгэх итгэл нэмэгдэж, хуулиар тогтоосон татвар өлөх үндсэн үүргээ биелүүлэх, сайн дураар татвар төлөх сэтгэлгээг төлөвшүүлэхэд ихээхэн нөлөөлсөн;

Улсын төсвийн орлого хяналтын газар нь 2009 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүн болон 2010 онд хэрэгжүүлэх гэж байгаа ажлынхаа талаар 2009 оны 11 дүгээр сард “Жишиг татварын алба - Загвар нэгж” сэдвээр, 2010 оны 1 дүгээр сард “Хөндлөнгийн мэдээллийг цуглуулах үүнийг хяналт шалгалтанд ашиглах нь” сэдэвт үзүүлэх сургуулийг Татварын ерөнхий газрын дарга, удирдлагууд, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга, Татварын улсын ахлах байцаагч /ТУАБ/-ыг оролцуулан зохион байгуулсан. Үүний үр дүнд бусад татварын албадаас манай газрын үйл ажиллагааны талаар туршлага судлан өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхлээд байгаа нь манай ажлын практик ач холбогдол юм. /Нийслэлийн, Сүхбаатар дүүргийн, Орхон аймгийн, Дархан-Уул аймгийн татварын хэлтсүүд гэх мэт/

## **ДҮГНЭЛТ**

Улсын төсвийн орлого хяналтын газар шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлсэний үр дүнд удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэр шинэ шатанд гарч, ажлын сахилга, хариуцлага дээшилснээр сар бүрийн татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлж, үйл ажиллагааны стандарт үзүүлэлтээрээ сүүлийн 2 жилд татварын албаны хэмжээнд тэргүүлээ.

Манай газрын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлж байгаа шинэлэг ажлууд нь татварын албаны өөрчлөлтийн эхлэл, татварын албаны “түүчээ” болж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Бид дэлхийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байгаа хөгжингүй орнуудын татварын албадын тэргүүлэх туршлагыг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн,

орчин үеийн оюунлаг татварын албыг бий болгох зорилтыг хэрэгжүүлэхэд бүх хүч чадлаа дайчлан шинийг санаачлан, гаргасан үр дүнгээ улам ахиулан ажиллах болно.

Бидний цаашдын үйл ажиллагаанд саад болж байгаа дараахь зүйлийг анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Татварын ерөнхий газрын бодлогын хэлтсүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах
2. Орон нутгийн татварын албадын үйл ажиллагаанд шинэчлэлийн бодлогыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахад анхааран ажиллах
3. Ажлын тэргүүн туршлага, шинэ санаачлагыг бодлогын түвшинд дэмжих
4. Мэдээллийн технологийн шийдлийг санхүүгийн болон удирдлагын талаас түргэн шуурхай шийдвэрлэдэг, дэмжин ажилладаг горимд шилжих
5. Татварын улсын байцаагчдын ажлын байрны шалгуур үзүүлэлт болон нормативыг тогтоох замаар боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх сэтгэлгээг хувь хүнд бий болгох
6. Татвар төлөгчдөөр ажлаа үнэлж, дүгнүүлэх ажлыг бүрэн нэвтрүүлж, өөрсдийн үйл ажиллагааны чиг хандлага, харилцааны соёл, үйлчилгээний чанарт дүгнэлт хийдэг системд шилжих

## **АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

1. “Татварын байгууллагын шинэчлэлийг өндөр хөгжилтэй орнуудын жишээ илтгэнэ” Ц.Оюунбаатар, Өдрийн сонин, 2009 он, #219(3296)
2. “Хямралаас гаргах амархан гарц байна” Я.Аюушжав, Үндэсний шуудан сонин, 2009 он, #090(492)
3. “Татвар төлөгчдөд төрийг үйлчилгээг соёлтой, шуурхай хүргэнэ” Я.Аюушжав, Зууны мэдээ сонин, 2010 он, #101(3479)
4. Шинэ хишигтэн сонин, 2009 он, тусгай дугаар
5. УТОХГ-ын 2009 оны жилийн, 2010 оны эхний хагас жилийн ажлын тайлан
6. Татварын албаны шинэчлэл, ил тодын хөтөлбөр, 2009 он
7. Татварын албаны хэмжээнд авилга, хээл хахуультай тэмцэх хөтөлбөр, 2009 он
8. “Татварын жишиг алба” хөтөлбөр, 2009 он
9. Татварын албаны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, 2009 он